



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/03-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК

Утас: 99862066

Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Дотоод хяналт	14
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
4.4 Материаллаг байдал	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Төлбөрийн акт	17
8.3 Зөвлөмж	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн Газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨБАУ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ААТҮГ	Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХСУХАТАУЗЗ	Хот, Суурин Ус Хангамж, Ариутгах Татуургын Ашиглалт, Үйлчилгээг зохицуулах зөвлөл
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
ОНӨГ	Орон Нутгийн Өмчийн Газар



“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА А.АЛТАНСҮХ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № ЦА-2022/03-НА-СТА-ОНА
тантай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

СЭА-2022/03-НА-СТА-ОНА

018020370

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,428,854.21	984,717.29
1.1.2	Дансны авлага	1,384,138,618.35	1,849,159,368.99
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	250,473,659.56	289,558,005.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,246,591.31	8,134,495.54
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10		0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,644,287,723.43	2,147,836,586.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,017,788,650.00	9,525,801,017.76
1.2.2	Биет бус хөрөнгө	655,459,450.00	668,179,450.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9		0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,673,248,100.00	10,193,980,467.76
1.3	Нийт хөрөнгийн дүн	12,317,535,823.43	12,341,817,054.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	92,274,260.21	67,927,948.58
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	750,905,215.96	769,180,526.49
2.1.1.4	НДШ - ийн өглөг	754,986,485.45	760,760,331.45
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,349,517.27	110,203,107.74
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12		0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,599,515,478.89	1,708,071,914.26
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00

2.1.2.2	Нөөц /ер төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	28,349,400.00	6,698,800.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	28,349,400.00	6,698,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,627,864,878.89	1,714,770,714.26
	ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.3	Өмч	1,574,064,600.00	1,574,064,600.00
2.3.1	-төрийн	0.00	0.00
2.3.2	-хувийн	0.00	0.00
2.3.3	-хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,326,522,257.69	10,326,522,257.69
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	186,177,656.00	208,993,441.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,397,093,569.15)	(1,482,533,958.37)
2.3.10		0.00	0.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,689,670,944.54	10,627,046,340.48
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	12,317,535,823.43	12,341,817,054.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,318,028,116.71	2,446,745,412.45
2	Борлуулалтын өртөг	2,011,660,926.22	2,444,430,259.18
3	Нийт ашиг (алдагдал)	-693,632,809.51	2,315,153.27
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	6,459.34	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	21,656,800.00	21,650,600.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	83,452,740.00	93,451,723.60
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	5,586,950.00	15,954,418.89
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-761,009,240.17	-85,440,389.22
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-761,009,240.17	-85,440,389.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-761,009,240.17	-85,440,389.22

23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,676,041,766.76	10,326,522,257.69	173,177,656.00	-518,096,797.28	11,657,644,883.17
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-101,977,166.76	0.00	0.00	-117,987,531.70	-219,964,698.46
2	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	173,177,656.00	-636,084,328.98	11,437,680,184.71
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-761,009,240.17	-761,009,240.17
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	13,000,000.00	0.00	13,000,000.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	186,177,656.00	-1,397,093,569.15	10,689,670,944.54
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
2	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	186,177,656.00	-1,397,093,569.15	10,689,670,944.54
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-85,440,389.22	-85,440,389.22
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00

5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	22,815,785.16	0.00	22,815,785.16
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	208,993,441.16	-1,482,533,958.37	10,627,046,340.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	14,333,229.34	166,571,917.61		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,262,525,814.81	2,257,060,131.25		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,240,869,014.81	2,235,409,531.25		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00		
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	21,656,800.00	21,650,600.00		
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	0.00		
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,248,192,585.47	2,090,488,213.64		
1.2.1	Ажиллагчдад төлсөн	662,349,457.51	822,380,020.78		
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,592,185.00	211,508,700.00		
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	214,357,907.95	424,144,724.43		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	200,426,740.39	359,877,056.96		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	56,752,670.00	71,353,510.62		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	21,365,000.00	8,119,339.16		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,036,313.93	177,144,442.80		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн				
1.2.9	Бусад мөнгөн зарлага	80,312,310.69	15,960,418.89		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,333,229.34	166,571,917.61		
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-14,315,640.66	-169,016,054.53		
2.1	Мөнгөн орлогын дүн	6,459.34	0.00		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	6,459.34	0.00		

2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	14,322,100.00	169,016,054.53
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,322,100.00	147,365,454.53
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	21,650,600.00
2.2.6		0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-14,315,640.66	-169,016,054.53
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4		0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5		0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,588.68	-2,444,136.92
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	3,411,265.53	3,428,854.21
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	3,428,854.21	984,717.29

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	1,339,691.40	2,647,259.00	2,468,393.90	178,865.10	93.2
	Үйл ажиллагааны орлого	м/төг	1,319,996.90	2,625,600.00	2,446,743.30	178,856.70	93.2
	Татаас санхүүжилт	м/төг	19,688.00	21650.8	21,650.60	0.20	100

	Бусад орлого	м/төг	6.5	8.2	0	8.20	
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	2,100,700.70	2,761,474.20	2,553,826.40	207,647.80	92.5
1	ЦАЛИН	м/төг	698,378.60	804,076.80	815,825.10	-11,748.30	101.5
2	НД-ийн шимтгэл	м/төг	99,611.70	217,103.94	122,852.50	94,251.44	56.6
3	ҮХ элэгдэл	м/төг	609,711.20	599,368.90	620,520.20	-21,151.30	103.5
4	Цахилгаан	м/төг	114,584.00	147,556.40	158,277.70	-10,721.30	107.3
5	Сэлбэг	м/төг		0.00	0	0.00	
6	Шатахуун	м/төг	49,838.60	72,000.00	71,353.50	646.50	99.1
7	Дулаан	м/төг	134735.6	146,496.20	146,496.90	-0.70	100.
8	Түлш	м/төг				0.00	
9	Буцалтгүй тусламж	м/төг	18,877.40	10,800.00	14,573.00	-3,773.00	134.9
10	Материал	м/төг	225,776.60	243,694.76	195,816.55	47,878.21	80.3
11	Холбоо	м/төг	11,418.70	20,130.80	13,854.00	6,276.80	68.8
12	Сургалт	м/төг		3,600.00	1400	2,200.00	38.8
13	Томилолт	м/төг	4,056.10	0.00	527.20	-527.20	
14	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	2574.5	557.50	1,202.10	-644.60	215.6
15	Үл ХХ-ийн татвар	м/төг	9,364.40	0.00	0.00	0.00	
16	НӨАТ, ХАОАТ, суутган	м/төг	45,169.80	194,660.00	174,390.05	20,269.95	89.6
17	Ус ашигласны татвар	м/төг	21,805.50	8,805.50	1,552.25	7,253.25	17.6
18	Урсгал засвар	м/төг	24157.9	201,638.00	135,145.45	66,492.55	67.0
19	Программ хангамжийн зардал	м/төг	1000	20,000.00	15,954.60	4,045.40	79.8
20	Аудитын зардал	м/төг	-	2,500.00	2700	-200.00	108.
21	Даатгал	м/төг	2388.1	3,840.10	4,002.60	-162.50	104.2
22	Маркетингийн зардал	м/төг	21365.2	50,715.00	41,428.10	9,286.90	81.7
23	Бусад зардал	м/төг	5,886.90	13,930.30	15,954.60	-2,024.30	114.5
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	-761,009.30	-114,215.20	-85,432.50	28,982.70	74.8
4	Орлогын татвар (3*10%)	м/төг				-	
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	-761,009.30	-114,215.20	-85,432.50	28,982.70	74.8

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ нь *“Байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно”* гэсэн зорилго дэвшүүлсэн байна.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын дүрэмд тус газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Гадаад худалдаа,

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” буюу 100 хувь орон нутгийн өмчийн эзэмшилд байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ нь анх Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Урсгал ус” орон нутгийн өмчийн ХХК нэртэйгээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д *“Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”*, 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх *“Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ууд,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,281.2 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,428.8	984.7	(2,444.1)
Авлага	1,384,138.6	1,849,159.3	465,020.7
Бараа материал	250,473.7	289,558.0	39,084.3
Урьдчилж төлсөн зардал	6,246.6	8,134.5	1,887.9
Үндсэн хөрөнгө	10,673,248.1	10,193,980.5	(479,267.6)
Нийт хөрөнгө	12,317,535.8	12,341,817.0	24,281.2
Богино хугацаат өр төлбөр	1,599,515.5	1,708,071.9	108,556.4
Урт хугацаат өр төлбөр	28,349.4	6,698.8	(21,650.6)
Эздийн өмчийн дүн	10,689,670.9	10,627,046.3	(62,624.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,317,535.8	12,341,817.0	24,281.2

Байгууллагын касс 38.8 мянган төгрөг, банкин дахь харилцах дансанд 945.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 2,444.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд касс болон харилцахаар 2,924,677.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,927,128.8 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 1,849,159.3 мянган төгрөг болж 465,020.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ХСУХАТАҮЗЗ-өөр дамжин төрөөс олгогдох цэвэр бохир усны төлбөрийн 10-12 дугаар сарын 416,856.3 мянган төгрөгийн санхүүжилт

дутуу ирсэн, аймгийн нэгдсэн эмнэлэг 70,192.5 мянган төгрөгийн цэвэр, бохир усны төлбөрийг дутуу төлснөөс голлон шалтгаалжээ.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 289,558.0 мянган төгрөг болж өмнөх оноос 39,084.3 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын засвар үйлчилгээнд шаардлагатай шугамын хаалт болон цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг бэлтгэн нөөцөлснөөс голлон шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс /анхны өртгөөр/ 12,116,559.3 мянган төгрөг болж 26,777.6 мянган төгрөгөөр буурсан нь 5,000.0 мянган төгрөгийн автобус, 9,800.0 мянган төгрөгийн ачааны машин, 12,720.0 мянган төгрөгийн санхүүгийн Diamond программ, 5,245.4 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж, 114,600.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 трансформатор, худгийн 3 санг тус тус худалдан авсан болон хөрөнгийн үнэлгээг 22,371.3 мянган төгрөгөөр бууруулсан, аймгийн ИТХТ-ийн 2021 оны 96 дугаар, 2019 оны 134 дугаар тогтоолын дагуу 2 автомашиныг акталсан, 7 автомашиныг дуудлага худалдаагаар худалдсан зэргээр 151,771.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр 108,556.4 мянган төгрөгөөр өссөн нь тус ААТҮГ-аар дамжин санхүүжигдэх Ерөө, Дулаанхаан, Бугант, Хүдэр, Жавхлант, Алтанбулаг сумдын цэвэр ус болон ариутгах татуургын үйлчилгээний төлбөрийн өглөгөөс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр 21,650.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд сумдыг худагжуулах төслийн хүрээнд Мянганы сорилын сангаас олгогдсон зээлийн үлдэгдлийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 10,627,046.3 мянган төгрөг болж, 62,624.6 төгрөгөөр буурсан нь Засгийн газрын оруулсан капиталын өсөлт болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн ОНӨГ-ын даргаар батлуулсан бөгөөд тайлант оны орлогыг 2,647,259.0 мянган төгрөгөөр, зардлыг 2,761,474.2 мянга төгрөгөөр, алдагдлыг 114,215.2 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 279,430.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,446,743.3 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, аймгийн төсвөөс 21,650.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийг авч, 2,553,826.4 мянган төгрөгийн зардал гарган, 85,432.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 2,468,393.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 178,856.9 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,553,826.4 мянган төгрөг болж, төлөвлөгөөг 207,647.8 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар хэмнэсэн нь орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, урсгал засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 330,962.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны алдагдал төлөвлөснөөс 28,782.7 мянган төгрөгөөр бага буюу 85,432.5 мянган төгрөг болсон байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардлын болон үндсэн хөрөнгийн дансны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Пийк ОМ Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн

хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн санхүүгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, бүртгэл тооцооны ажлыг стандартын дагуу, хууль журмын хүрээнд гүйцэтгэж, тайлагнаж санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үнэлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардал 2,553,836.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,538.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 17,876.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, -6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Сэлэнгэ Цэнгэг Ус” ААТҮГ нь тайлант онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 111 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 38 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгснөөс 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй бөгөөд зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	49,018.4	1	29,411.0	1	19,607.4	50
Зөвлөмж	4	47,412.5	4	47,412.5			100
Нийт дүн	6	96,430.9	5	76,823.5	1	19,607.4	83.3

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлээгүй зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

7.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан орлогын дэлгэрэнгүй тайланд тусгагдсан борлуулсан бүтээгдэхүүний өртөг, удирдлагын зардлын хуваарилалт болон үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, элэгдлийн зардлын бүртгэлийг тулган баталгаажуулах боломжгүй байсан тул дараагийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай юм.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79,430.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,230.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 14,800.0 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй давтан гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага тус тус хүргүүлж, 62,400.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 17,030.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 17,876.8 мянган төгрөгийн түвшнээс 846.0 мянган төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажил олгогчийн шийдвэргүйгээр дарга А.Алтансүх, ерөнхий нягтлан бодогч Г.Сувд нарт 2,230.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож, биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг... ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна” гэж заасантай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг биеэр нөхөн эдлүүлэх, зайлшгүй тохиолдолд ажил олгогчийн шийдвэрийн дагуу цалин, урамшууллыг холбогдох хувь, хэмжээгээр тооцон олгох, давхардуулан олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 5,000.0 мянган төгрөгийн Istana маркийн бага оврын автобус, 9,800.0 мянган төгрөгийн Mighty маркийн ачааны машиныг 2021 оны 12 дугаар сарын 27-нд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалт болон аймгийн ОНӨГ-ын даргын баталсан “Урсгал ус ХХК-ийн 2021 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 62,400.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/								
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	"Сэлэнгэ Цэнгэг Ус" ОНӨААТҮГ	СЭА-2022/03/НА-СТА-ОНӨ	Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ажил олгогчийн шийдвэргүйгээр 2 албан хаагчид цалин давхардуулан олгосон	Төлбөрийн акт тогтоосон	1	2,230.8			1.	2,230.8					
2	"Сэлэнгэ Цэнгэг Ус" ОНӨААТҮГ	СЭА-2022/03/НА-СТА-ОНӨ	Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 авто машины худалдан авалт хийсэн	Албан шаардлага хүргүүлсэн	1	14,800.0					1	14,800.0			
3	"Сэлэнгэ Цэнгэг Ус" ОНӨААТҮГ	СЭА-2022/03/НА-СТА-ОНӨ	Бараа материалын худалдан авалт нь цахим баримтаар баталгаажаагүй	Зөвлөмж	1	62,400.0								1 62,400.0	
ДҮН					3	79,430.8			1.	2,230.8	1	14,800.0	-	-	1 62,400.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	"Сэлэнгэ Цэнгэг Ус" ОНӨААТҮГ	СЭА-2022/03/НА-СТА-ОНӨ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 38 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн	1								1		
ДҮН					1	-							1		
НИЙТ ДҮН					5	79430.8			1	2,230.8	1	14,800.0	1	1 62,400.0	